



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАЯНХОНГОР СУМЫН ИТХ-ЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: БНА-2021/70/СТА/ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2021 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyma@audit.gov.mn Аудитор: Н.Бүнчинсүрэн Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsuren@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	5
2.1.Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3.Аудитын тайлан	10
3.1. Ерөнхий зүйл	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	11
3.4. Материаллаг байдал.....	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	12
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.9. Аудитын илрүүлэлт	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	14
3.9. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	14
4. Менежментийн захидал.....	15
5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	17



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Ж.БЯМБАСҮРЭН
ТАНАА

2021.02.25 № 2/158
танай _____ -ны № _____ -т

Г **АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ** Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 56 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

2021 А4 ТООТ

• 005020164

Байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Баянхонгор сумын ИТХ-ын дарга баталж, гүйцэтгэлийн тайланг Баянхонгор сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

2.1. Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6,235,004.82	14,560,993.00
33	АВЛАГА	560,411.82	370,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	560,411.82	00.00
335	Бусад авлага	00.00	370,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	370,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	5,674,593.00	14,190,993.00
354	Хангамжийн материал	5,674,593.00	14,190,993.00
35410	Бичиг хэргийн материал	213,500.00	423,500.00
35420	Аж ахуйн материал	1,129,250.00	1,564,250.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,920,000.00	4,126,400.00
35450	Барилгын засварын материал	820,010.00	820,010.00
35470	Бусад хангамжийн материал	1,591,833.00	7,256,833.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	11,704,930.55	22,829,074.94
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	11,704,930.55	22,829,074.94
392	Биет хөрөнгө	11,539,930.67	22,741,574.74
39203	Авто-тээврийн хэрэгсэл	47,492,000.00	54,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-39,236,277.71	37,779,166.69
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	9,925,900.00	14,285,900.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-7,438,566.62	-9,038,733.57
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,064,340.00	6,409,340.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,407,465.00	-5,575,765.00
39217	Ном	140,000.00	140,000.00
393	Биет бус хөрөнгө	164,999.88	87,500.20
39301	Програм хангамж	375,000.00	175,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-210,000.12	-87,499.80
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	17,939,935.37	37,390,067.94
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	17,939,935.37	37,390,067.94
51	Засгийн газрын хувь оролцоо	17,939,935.37	37,390,067.94
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	21,281,230.42	21,281,230.42
51101	Өмч: - төрийн	21,281,230.42	21,281,230.42
512	Хуримтлагдсан үр дүн	-5,428,320.89	14,021,811.68
51210	Өмнөх үеийн үр дүн	-5,428,320.89	-5,428,320.89
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	19,450,132.57
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,087,025.84	2,087,025.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	17,939,935.37	37,390,067.94

2.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	143,915,800.00	246,059,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	220,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	220,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	220,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	220,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	143,915,800.00	245,839,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	500,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	143,415,800.00	245,839,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	143,415,800.00	245,839,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	150,878,262.19	225,608,667.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	150,878,262.19	225,608,667.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	150,850,453.46	222,549,745.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	101,945,184.61	130,463,648.70
210101	Үндсэн цалин	82,851,164.61	107,226,938.16
210104	Урамшуулал	19,094,020.00	23,236,710.54
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,801,368.84	16,718,900.28
210201	Тэтгэврийн даатгал	8,754,268.84	11,675,034.86
210202	Тэтгэмжийн даатгал	1,011,800.00	1,167,548.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	809,400.00	1,114,563.28
210204	Ажилгүйдлийн даатгал	202,400.00	248,601.31
210205	Эрүүл мэндийн даатгал	2,023,500.00	2,513,151.97
2104	Хангамж, бараа материалын зардал	7,289,261.00	10,174,232.54
210401	Бичиг хэрэг	3,315,050.00	4,155,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,404,600.00	5,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	569,611.00	336,232.54
210404	Ном, хэвлэл	00.00	183,000.00
2105	Нормативт зардал	2,667,600.00	4,299,968.00
210502	Хоол, хүнс	2,667,600.00	4,299,968.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	759,500.00
210604	Урсгал засвар	00.00	759,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,844,200.00	295,000.00
210702	Дотоод албан томилолт	1,844,200.00	295,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	736,040.00	1,267,975.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	736,040.00	1,062,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	205,175.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,566,799.01	58,570,520.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,390,500.00	47,690,665.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,990,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,186,299.01	10,879,855.85
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,808.73	3,058,922.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	700,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	2,358,922.30
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,358,922.30

Баянхонгор сумын ИТХ-ын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,808.73	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,808.73	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-6,962,462.19	20,451,132.33
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	1,000,999.76
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	1,000,999.76
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-1,000,999.76
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-6,962,462.19	19,450,132.57

2.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөг/
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	143,915,800.00	245,839,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	143,915,800.00	245,839,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	500,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	143,415,800.00	245,839,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	143,415,800.00	245,839,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	143,915,800.00	222,834,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	143,915,800.00	222,834,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	143,887,991.27	219,775,877.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	102,506,190.27	129,903,236.88
210101	Үндсэн цалин	83,241,190.27	106,666,526.88
210104	Урамшуулал	19,265,000.00	23,236,710.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,813,300.00	16,718,900.28
210201	Тэтгэврийн даатгал	8,766,200.00	11,675,034.86
210202	Тэтгэмжийн даатгал	1,011,800.00	1,167,548.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	809,400.00	1,114,563.28
210204	Ажилгүйдлийн даатгал	202,400.00	248,601.31
210205	Эрүүл мэндийн даатгал	2,023,500.00	2,513,151.97
2104	Хангамж, бараа материалын зардал	7,020,161.00	10,384,232.54
210401	Бичиг хэрэг	2,779,550.00	4,365,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,632,000.00	5,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	608,611.00	336,232.54
210404	Ном, хэвлэл	00.00	183,000.00
2105	Нормативт зардал	2,667,600.00	7,799,968.00
210502	Хоол, хүнс	2,667,600.00	4,299,968.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	3,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	2,965,900.00
210604	Урсгал засвар	00.00	2,965,900.00
2107	Томилолт, зочны зардал	1,844,200.00	295,000.00
210702	Дотоод албан томилолт	1,844,200.00	295,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,236,040.00	1,267,975.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,236,040.00	1,062,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	205,175.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,800,500.00	50,440,665.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,803,800.00	50,440,665.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,996,700.00	00.00

Баянхонгор сумын ИТХ-ын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,808.73	3,058,922.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	700,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	2,358,922.30
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,358,922.30
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,808.73	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,808.73	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	23,005,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	23,005,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	23,005,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	23,005,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	23,005,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-23,005,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,281,230.42	2,087,025.84	8,946,498.19	32,314,754.45
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-14,374,819.08	-14,374,819.08
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,281,230.42	2,087,025.84	-5,428,320.89	17,939,935.37
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,281,230.42	2,087,025.84	-5,428,320.89	17,939,935.37
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	21,281,230.42	2,087,025.84	-5,428,320.89	17,939,935.37
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	19,450,132.57	19,450,132.57
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,281,230.42	2,087,025.84	14,021,811.68	37,390,067.94

2.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	245,839,800.00	243,480,877.70	2,358,922.3	99.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	245,839,800.00	243,480,877.70	2,358,922.3	99.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	245,139,800.00	242,780,877.70	2,358,922.3	99.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	129,991,000.00	129,903,236.88	87,763.1	99.9
210101	Үндсэн цалин	106,744,700.00	106,666,526.88	78,173.1	99.9
210104	Урамшуулал	23,246,300.00	23,236,710.00	9,590.0	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,607,000.00	16,718,900.28	1,888,099.7	89.9
210201	Тэтгэврийн даатгал	13,217,000.00	11,675,034.86	1,541,965.1	88.3
210202	Тэтгэмжийн даатгал	1,347,500.00	1,167,548.86	179,951.1	86.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,078,000.00	1,114,563.28	-36,563.3	103.4
210204	Ажилгүйдлийн даатгал	269,500.00	248,601.31	20,898.7	92.2

**Баянхонгор сумын ИТХ-ын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210205	Эрүүл мэндийн даатгал	2,695,000.00	2,513,151.97	181,848.0	93.3
2104	Хангамж, бараа материалын зардал	10,416,000.00	10,384,232.54	31,767.5	99.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	344,000.00	336,232.54	7,767.5	97.7
210404	Ном, хэвлэл	207,000.00	183,000.00	24,000.0	88.4
2105	Нормативт зардал	7,800,000.00	7,799,968.00	32.0	100.0
210502	Хоол, хүнс	4,300,000.00	4,299,968.00	32.0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,268,900.00	1,267,975.00	925.0	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,062,900.00	1,062,800.00	100.0	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	206,000.00	205,175.00	825.0	99.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50791000.00	50440665.00	350,335.0	99.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,791,000.00	50,440,665.00	350,335.0	99.3
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	245,839,800.00	243,480,877.70	2,358,922.3	99.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	245,839,800.00	243,480,877.70	2,358,922.3	99.0
132001	Орон нутгийн төсвөөс	245,839,800.00	243,480,877.70	2,358,922.3	99.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25.00	25.00	0.0	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	02.00	02.00	0.0	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТУ)	02.00	02.00	0.0	100.0
650010	Гэрээт ажилтан	10.00	10.00	0.0	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	11.00	11.00	0.0	100.0

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын ИТХ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг ИТХ-ын нарийн бичгийн дарга Ж.Бямбасүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 сарын 24-аас 2021 оны 02 сарын 25-ны хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор сумын ИТХ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтээ Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020.01.20-ны өдрийн 16/8 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баянхонгор сумын ИТХ-ын эрхэм зорилго нь ардчилсан нийгэм дэх зах зээлийн эдийн засгийн харилцааны орон нутгийн удирдлагын үйл ажиллагааг нийцүүлэн орон нутгийн бие даасан хөгжлийг хангах, Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлж сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бодлогыг зүй зохистой тодорхойлон түүнийг хэрэгжүүлэхэд сумын иргэдийн бүтээлч санаачилга, идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх, сумын Засаг дарга түүний Тамгын газар, төр, орон нутгийн өмчит байгууллагуудын үйл ажиллагааг эрчимжүүлэн чанаржуулж төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, тэдний язгуур, эрх ашгийг дээдлэн аж байдлыг хэлбэрэлтгүй нэмэгдүүлэн нутгийн өөрийн удирдлагын чадавхыг дээшлүүлэх явдал юм.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянхонгор сумын ИТХ-ын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү, хяналт, аудитын алба нь 2020 онд харьяа орон нутаг Баянхонгор сумын ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийгээгүй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны 4 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшин “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшин 2020 оны 4 дугаар улирлын нийт зардлын 226609.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 4532.2 мянга, гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өөрчлөөгүй.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянхонгор сумын ИТХ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 13208.0 мянга өмнөх оноос 7388.7 мянган төгрөгөөр буюу 123 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6,235.0	14,561.0	8,326.0
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	560.4	370.0	(190.4)
Бараа материал	5,674.6	14,191.0	8,516.4
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	11,704.9	22,829.1	11,124.1
Үндсэн хөрөнгө	63,997.2	75,310.2	11,313.0
Хуримтлагдсан элэгдэл	(52,292.3)	(52,481.2)	(188.9)
Нийт хөрөнгө	17,939.9	37,390.1	19,450.1
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	17,939.9	37,390.1	19,450.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	17,939.9	37,390.1	19,450.1

Авлага данс нь оны эхэнд ажиллагсдаас авах авлага 560.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант хугацаанд барагдуулж сумын ИТХ-ын төлөөлөгч

М.Батбаярт төлөөлөгчдийн суудлын зардлыг давхардуулан 720.0 төгрөг илүү олгож 350.0 мянган төгрөгийг суутгаж 370,0 төгрөгийг авлагаар санхүүгийн тайланд тусгасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 14191.0 мянган төгрөг болж 8516.4 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материал 210.0 мянга, аж ахуйн материал 435.0 мянга, сэлбэг хэрэгсэл 2206.4 мянга, бусад хангамжийн материал 5665.0 төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 75310.2 мянган төгрөг болж 11313.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 23005,0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020.11.06-ны өдрийн 108 дүгээр тогтоолоор 200.0 мянган төгрөгийн архивын программ, 11492.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл акталсантай холбоотой байна. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020.03.04-ны өдрийн 20 дугаар тогтоолоор сумын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй Toyota brevis автомашиныг нээлттэй дуудлагын худалдааны доод үнийг 20 хувиар бууруулж 1430.1 мянган төгрөгөөр тогтоосон байна. Үүний дагуу дуудлага худалдааг зохион байгуулж 1630.0 мянган төгрөгөөр худалдаж аймгийн орон нутгийн өмчийн газарт орлого орсон байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 37390.0 мянган төгрөг болж 19450.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 246059.8 мянган төгрөг болж өмнөх оноос 102144.0 мянган төгрөгөөр буюу 70.9 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 102144.0 мянган төгрөгийн орлого байна. Энэ нь орон нутгийн төсвөөс авах санхүүжилт 102424.0 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал 225608.7 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 74730.4 мянган төгрөгөөр буюу 49.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд байна. Энэ нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ, хангамж бараа материалын зардал, нормативт зардал, урсгал засварын зардал, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал өссөнтэй холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 204156.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 204156.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 44927.6 мянган төгрөгөөр өсгөж 24908368 мянган төгрөгөөр баталсан. Энэ нь багаж техник хэрэгслийн зардлыг төлөвлөсөн хэмжээнээс нэмэгдүүлж баталсантай холбоотой байна.

Тайлант онд анх баталсан 249083.8 мянган төгрөг ба тодотголоор 3244.0 мянган төгрөгөөр бууруулж 214290.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь цалин, НДШ, шуудан холбоо, дотоод албан томилолт, хичээл үйлдвэрлэлийн зардлыг бууруулж, бичиг хэрэг, нормын хувцас, зөөлөн эдлэл, хоол хүнс, урсгал засвар, ном хэвлэл, бараа үйлчилгээний бусад зардал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг тус тус нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 245839.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 245839.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 245839.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 243480.9 мянган төгрөгийг зарцуулж, 2358.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 243480.9 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 87.7 мянга, НДШ 1888.1 мянга, хангамж, бараа материалын зардал 31.7 мянга, бусад бараа үйлчилгээний зардал 350.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 139 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 10 мэдээлэл байна. Үүнд төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авах ажиллагаа, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1 гүйлгээний 28062.5 мянга, зарлагын 1 гүйлгээний 6500.0 мянган төгрөгийн мэдээллийг хоцроож мэдээлсэн байна.

**Баянхонгор сумын ИТХ-ын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд нь байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуулаагүй	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9			2
2	Хагас жил	4	4				
3	Улирал бүр	1	4	3	1		
4	Сар бүр	3	36	36			
5	Тухай бүр	8	96	87	9		
6	Нийт	27	151	139	10		2

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайланд 560,0 мянган төгрөгийн залруулга хийгдсэн ба акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 798.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 370.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 428.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж хүргүүлээ.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 798.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 370.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 428.4 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 2 заалт бүхий зөвлөмж өгөв. Үүнд:

1. Авлага данс нь оны эхэнд ажиллагсадаас авах авлага 560.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант хугацаанд барагдуулж сумын ИТХ-ын төлөөлөгч М.Батбаярт төлөөлөгчдийн суудлын зардлыг давхардуулан 720.0 төгрөг илүү олгож 350.0 мянган төгрөгийг суутгаж 370.0 төгрөгийг авлагаар санхүүгийн тайланд тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5."Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 6 дугаар зүйлийн 6.4.1."Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: М.Батбаярт илүү олгосон 370.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.9. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Байхгүй.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1.1 Илрүүлэлт

Баянхонгор сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020.12.23-ны өдрийн 43 дугаар тогтоолоор хурлын тэргүүлэгчдэд цалингийн сангаас 1785.0 мянган төгрөгийн урамшуулал олгохдоо НДШ суутгаагүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6. “Ажил олгогч, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа тэтгэвэр авагч энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 5 дахь заалтад зааснаас бусад төрлийн даатгалд албан журмаар даатгуулна. Үндсэн ажлаас гадуур байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу давхар ажил эрхэлж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалтад зааснаас бусад төрлийн даатгалд албан журмаар даатгуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2. Эрсдэл

Цалин, НДШ, ХХОАТ-ын зардлыг илүү дутуу тооцох

1.3 Өгсөн зөвлөмж

Цалин хөлс түүнтэй адилтгах орлогоос НДШ-ийг хуулийн дагуу үнэн зөв тооцон холбогдох мэдээллийг бүрэн мэдээлж байх

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

2.1 Илрүүлэлт

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 139 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 10 мэдээлэл байна. Үүнд төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авах ажиллагаа, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1 гүйлгээний 28062.5 мянга, зарлагын 1 гүйлгээний 6500.0 мянган төгрөгийн мэдээллийг хоцроож мэдээлсэн байна.

2.2. Эрсдэл

Хуульд заасан мэдээллийг байршуулаагүй байх

2.3 Өгсөн зөвлөмж

Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсний дагуу дээрх хугацаа хоцроож байршуулсан мэдээллийг хугацаанд мэдээлж байх.

2.4.Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

2.5.Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Н.Бунчинсүрэн

Н.БҮНЧИНСҮРЭН
ОГНОО: 2021.02.25

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР

А.Цээням



А.ЦЭЭНЯМ
ОГНОО: 2021.02.25

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ
ОГНОО: 2021.02.25

5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			БНА- 2021/70/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Баянхонгор сумын ИТХ		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Баянхонгор сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020.12.23-ны өдрийн 43 дугаар тогтоолоор хурлын тэргүүлэгчдэд цалингийн сангаас 1785.0 мянган төгрөгийн урамшуулал олгохдоо НДШ суутгаагүй байна	428.4	Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	Ж.Бямбасүрэн А.Цагаандолгор
2	Сумын ИТХ-ын төлөөлөгч М.Батбаярт төлөөлөгчдийн суудлын зардлыг давхардуулан 720.0 төгрөг илүү олгож 350.0 мянган төгрөгийг суутгаж 370.0 төгрөгийг авлагаар санхүүгийн тайланд тусгасан байна.	370.0	Төлбөрийн акт тогтоох	Дарга Нягтлан бодогч	Ж.Бямбасүрэн А.Цагаандолгор
3	Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 139 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 10 мэдээлэл байна		Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	Ж.Бямбасүрэн А.Цагаандолгор
ДҮН		798.4			

-----oO-----